



# ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ СТРАТЕГИЙН БАРИМТ БИЧИГ




**2018-2021 он**

**СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ**

**Эрчим хүчний зохицуулах хорооны 2018 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 256 дугаар тогтоолоор батлав.**

## НЭГ. ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ СТРАТЕГИ



## ХОЁР. МАНДАТ

### Эрчим хүчний зохицуулах хорооны МАНДАТ

- Эрчим хүч үйлдвэрлэх, дамжуулах, түгээх, импортлох, экспортлох, диспетчерийн зохицуулалт хийх, хангах үйл ажиллагааг зохицуулах;
- Эрчим хүчний үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, сунгах, өөрчлөх, түдгэлзүүлэх, хүчингүй болгох;
- Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг тогтоох, хэрэгжилтийг хянах;
- Тариф тогтоох аргачлал боловсруулах, индексжүүлэх;
- Тусгай зөвшөөрөл эзэмшигч болон хэрэглэгчийн тарифыг хянаж батлах;
- Тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн хүрээнд шударга өрсөлдөөнийг бий болгох нөхцлийг бүрдүүлэх;
- Тусгай зөвшөөрөл эзэмшигч, хэрэглэгчийн эрх ашгийг тэнцвэртэй хамгаалах;
- Эрчим хүч хэмнэлтийн бодлогыг хэрэгжүүлэх, зохицуулах;
- Аймаг, нийслэлийн зохицуулах зөвлөлүүдийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах.

### Эрчим хүчний зохицуулах хорооны үйл ажиллагаанд холбогдогч талууд



## **ГУРАВ. ЭРХЭМ ЗОРИЛГО**

***Монгол Улсын тогтвортой хөгжил, иргэдийн амьдралын чанарыг хангахад чиглэсэн эрчим хүчний найдвартай, үр ашигтай, байгаль орчинд ээлтэй технологи, үйл ажиллагааг дэмжсэн зохицуулалтын тогтолцоог төлөвшүүлнэ.***

## **ДӨРӨВ. АЛСЫН ХАРАА**

***Эрчим хүч хэрэглэгч, хангагчийн итгэл хүлээсэн хөгжилд хөтлөх мэргэшсэн манлайлагч байгууллага байна.***

## **БИДНИЙ УРИА:**

***Ухаалаг зохицуулалт – хөгжлийн ирээдүй***



## **ТАВ. ЭРХЭМЛЭХ ЗҮЙЛС, ЗАРЧИМ**

Эрчим хүчний зохицуулах хороо нь үйл ажиллагааны эрхэм зорилго, стратегийн зорилтуудыг хэрэгжүүлэхдээ дор дурдсан эрхэмлэх зүйлсийг баримтална.

- **Найдвартай** – Эрчим хүчээр тасралтгүй хангах, аюулгүй байх, хангагч, хэрэглэгчийн эрх ашгийг тэнцвэртэй хамгаалах;
- **Үр ашигтай** – Эрчим хүч хэмнэлтийн бодлогыг хэрэгжүүлэх, өрсөлдөөнт зах зээлийг бий болгох, үнэ тарифыг оновчтой тогтоох;
- **Байгаль орчинд ээлтэй** – Эрчим хүчний үйлдвэрлэл, хэрэглээнд хэмнэлттэй, байгаль орчинд сөрөг нөлөө багатай дэвшилтэт технологи ашиглахыг дэмжих.

Эрчим хүчний зохицуулах хорооны стратегийн зорилго, зорилтыг хэрэгжүүлж, байгууллагын соёлыг төлөвшүүлэх үндсэн суурь нь дор дурдсан үйл ажиллагааны зарчмууд байна. Үүнд:

- **Хараат бус байх** - Үйл ажиллагаагаа хэрэгжүүлэхдээ нөлөөнд автахгүй, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх;
- **Хууль дээдлэх** – Үйл ажиллагаандаа хуулийг хэлбэрэлтгүй сахин биелүүлэх, хэрэглэх, хуульд нийцсэн шийдвэр гаргах;
- **Ил тод байх** – Хуулиар нууцын зэрэглэлд хамаарахаас бусад мэдээлэл нь олон нийтэд нээлттэй, ил тод, ойлгомжтой байх;
- **Тэгш шударга байх** – Нийтийн ашиг сонирхлыг эрхэмлэн эрчим хүч хэрэглэгч, хангагчийн эрх ашгийг тэнцвэртэй хамгаалж, адил тэгш боломжоор хангах;
- **Хэрэглэгчийг дээдлэх** – Хэрэглэгчийн хууль ёсны эрх ашгийг хамгаалах, дээдлэх;
- **Мэргэшсэн байх** – Ажил үүргээ мэргэжлийн өндөр түвшинд гүйцэтгэх, ажилтны мэдлэг чадварыг эрхэмлэх.

## **ЗУРГАА. СТРАТЕГИЙН ЗОРИЛГО**

Эрчим хүчний зохицуулах хорооны 2018-2021 оны стратегийн төлөвлөгөөний хүрээнд дараах таван үндсэн стратегийн зорилгыг дэвшүүлэв.

Үүнд:


- Стратегийн зорилго 1:** Эрчим хүчний салбарыг зохицуулалттай, өрсөлдөөнт зах зээлийн зарчмаар ажиллах нөхцлийг бүрдүүлэх;
- Стратегийн зорилго 2:** Эрчим хүчний тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн үйл ажиллагааг зах зээлийн зарчимд нийцүүлэн үр дүнг чухалчилсан зохицуулалтаар хангах;
- Стратегийн зорилго 3:** Инноваци, дэвшилтэт техник, технологид суурилсан эрчим хүчний хангамж, хэрэглээний хэмнэлт, үр ашгийг нэмэгдүүлэх;
- Стратегийн зорилго 4:** Эрсдэлд суурилсан хяналт шалгалтын тогтолцоог нэвтрүүлэх;
- Стратегийн зорилго 5:** Мэдлэг чадварт суурилсан мэргэшсэн манлайлагч байгууллага болох.

### **Эрчим хүчний зохицуулах хорооны стратегийн зорилгуудын харилцан уялдаа**

Эрчим хүчний зохицуулах хорооны мандатад тулгуурласан стратегийн таван зорилго нь тус хорооны эрхэм зорилгыг хэрэгжүүлж, алсын хараанд хүрэхэд чиглэгдэх юм. Ингэхдээ тус хороо нь үйл ажиллагаандаа “найдвартай, үр ашигтай, байгаль орчинд ээлтэй” байх зарчмыг эрхэмлэж “Ухаалаг зохицуулалт – хөгжлийн ирээдүй” гэсэн урианд хөтлөгдөн ажиллана.

Эрчим хүчний зохицуулах хорооны стратегийн таван зорилго нь өөр хоорондоо нягт уялдаатай хэрэгжинэ. Энэ уялдааг дараах зургаар үзүүлэв (Зураг 1).

**Зураг 1. Стратегийн зорилгуудын харилцан уялдаа**




Эрчим хүчний зохицуулах хорооны стратегийн нэгээс дөрөвдүгээр зорилгыг хэрэгжүүлэх нөхцөл нь тус хорооны нийт албан хаагчдын мэдлэг чадварыг хөгжүүлж, мэргэшсэн манлайлагч байгууллага болоход чиглэгдсэн стратегийн тавдугаар зорилго байх болно.




## ДОЛОО. ЭХЗХ-НЫ СТРАТЕГИЙН ЗУРАГЛАЛ

### ЭХЗХ-НЫ СТРАТЕГИЙН зураглал – ХҮРЭХ ҮР ДҮН (2018-2021)



ЭХЗХ-ны стратегийн зураглал – ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ (2018-2021)



**Стратегийн 1 дүгээр зорилго: Эрчим хүчний салбарыг зохицуулалттай, өрсөлдөөнт зах зээлийн зарчмаар ажиллах нөхцлийг бүрдүүлэх.**

Ерөнхий чиглэл	Зорилт	Үйл ажиллагаа	Дунд хугацааны хүрэх үр дүн
Тусгай зөвшөөрөл эзэмшигч, хэрэглэгч	<ul style="list-style-type: none"> <li>Бодит өртөг, ашгийн зохих түвшинг хангасан, үнэ тарифийн тогтолцоо бий болгох;</li> <li>Эрчим хүчний салбарын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Эрчим хүчний үнэ тарифын өнөөгийн нөхцөл байдлыг судалж, тарифын бодлогыг оновчлох</li> <li>ТЗЭ-ийн өртөг, зардалд дүн шинжилгээ хийж, тэдгээрийн зардлыг бууруулах урамшуулалт зохицуулалтын арга хэлбэрийг нэвтрүүлэх</li> <li>Эрчим хүчний үнэ тарифыг индексжүүлэх ажлыг зохион байгуулж, хэрэгжүүлэх</li> <li>Хэрэглэгчийн өргөдөл, гомдол, хүсэлтэд тулгуурласан эргэх холбоо бүхий үйл ажиллагааны нэгдсэн системийг нэвтрүүлж хэрэгжүүлэх</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Эрчим хүчний салбарын санхүүгийн тогтвортой байдал хангагдсан байна.</li> <li>Эрчим хүчний салбар дахь хувийн хэвшлийн оролцоо нэмэгдсэн байна.</li> <li>Иргэд бодит өртөг бүхий найдвартай эрчим хүчээр хангагдана.</li> </ul>
Дотоод үйл ажиллагаа	<ul style="list-style-type: none"> <li>Эрчим хүчний салбарыг зохицуулалттай, өрсөлдөөнт зах зээлийн зарчмаар ажиллах загвар, дүрэм, журамтай болох.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Зохицуулалттай, өрсөлдөөнт зах зээлийн зарчмаар ажиллах эрчим хүчний салбарын нөхцөл, боломжийг судлах.</li> <li>Эрчим хүчний зах зээлийн загварууд, тэдгээрийн хөгжлийн чиг хандлагыг олон улсын түвшинд судлах</li> <li>Эрчим хүчний салбарын нөхцөл байдалд тохирсон өрсөлдөөнийг дэмжсэн зах зээлийн загварыг судалж, боловсруулж гаргах</li> <li>Эрчим хүчний зах зээлд оролцогч талуудын үйл ажиллагааны зарчим, дүрэм, журмыг боловсруулж хэрэгжүүлэх</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Эрчим хүчний салбар зохицуулалттай, өрсөлдөөнт зах зээлийн зарчмаар ажилладаг болсон байна.</li> </ul>
Санхүү	<ul style="list-style-type: none"> <li>Нөөцийг үр ашигтай ашигладаг болох</li> <li>Салбарын санхүү бүртгэлийн нэгдсэн бодлогын баримт бичигтэй болох.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Нөөц (санхүү, хүн, материаллаг)-ийг үр ашигтай хуваарилж, зарцуулах төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлнэ.</li> <li>Хөрөнгө оруулалтыг татах эрчим хүчний бодит өртгийг тодорхойлж, тарифын шинэтгэлийг үе шаттайгаар хэрэгжүүлэх</li> <li>Салбарын санхүү бүртгэлийн нэгдсэн бодлогын баримт бичгийг боловсруулж, хэрэгжүүлэх</li> <li>Салбарын нягтлан бодох бүртгэлийн дансны нэгдсэн систем нэвтрүүлэх ажлыг зохион байгуулж, хэрэгжүүлэх.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>ЭХЗХ-ны санхүүгийн тогтвортой байдал хангагдсан байна.</li> <li>Салбарын санхүү бүртгэлийн үйл ажиллагаа нь нэгдмэл бодлогын дагуу явагддаг болсон байна.</li> </ul>
Сургалт, хөгжил	<ul style="list-style-type: none"> <li>Үнэ тарифыг индексжүүлэх, өртөг зардлын шинжилгээ, зах зээлийн судалгаа хийх арга зүйг ажилтнууд бүрэн эзэмшсэн байх.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Ажилтнуудын мэдлэг чадварын хэрэгцээг судалж, сургалтын хөтөлбөр төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Эрчим хүчний үнэ тариф, өртөг зардлын тооцоо, зах зээлийн судалгаа нь алдаагүй хийгддэг болно.</li> </ul>

**Стратегийн 2 дугаар зорилго: Эрчим хүчний тусгай зөвшөөрөл  
эзэмшигчдийн үйл ажиллагааг зах зээлийн  
зарчимд нийцүүлэн үр дүнг чухалчилсан  
зохицуулалтаар хангах**

Ерөнхий чиглэл	Зорилт	Үйл ажиллагаа	Дунд хугацааны хүрэх үр дүн
Тусгай зөвшөөрөл эзэмшигч, хэрэглэгч	<ul style="list-style-type: none"> <li>ТЗЭ-чдэд тавигдах нөхцөл, шаардлагыг тодорхой болгох.</li> <li>Тусгай зөвшөөрөл олгох, сунгах, цуцлах, өөрчлөх үйл ажиллагааг шинэчлэгдсэн шаардлагын дагуу хэрэгжүүлэх.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Эрчим хүчний зах зээлийн загварт нийцсэн тусгай зөвшөөрөл олгох, сунгах, цуцлах, өөрчлөх үйл ажиллагаанд тавигдах шаардлага, нөхцлийг боловсруулж, хэрэгжүүлэх</li> <li>ТЗЭ-ийн үйл ажиллагааны өнөөгийн нөхцөл байдалд судалгаа хийж, цаашид авах арга хэмжээг төлөвлөх</li> <li>ТЗЭ-дийн үйл ажиллагааны үр дүнг хэмжих шалгуур үзүүлэлтийг тодорхойлох</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Тусгай зөвшөөрөлтэй холбогдсон үйл ажиллагаа нь зах зээлийн загварт суурилсан байна.</li> </ul>
Дотоод үйл ажиллагаа	<ul style="list-style-type: none"> <li>Тусгай зөвшөөрөл олгох, сунгах, цуцлах, өөрчлөх үйл ажиллагааны дүрэм, журмыг шинэчлэх.</li> <li>ТЗЭ-ийн үйл ажиллагааны талаар мэдээллийн нэгдсэн сан бий болгох.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Орцод суурилсан механизмаас үр дүнд суурилсан зохицуулалтын механизмд шилжүүлэх ажлыг зохион байгуулж, хэрэгжүүлэх</li> <li>ТЗЭ-дийн үйл ажиллагааны үр дүнг (хүний нөөцийн болон санхүүгийн менежментийн бодлого, техник, технологийн бодлого, эрчим хүч хэмнэлтийн бодлого, хөтөлбөр) чухалчилсан зохицуулалтын механизмыг нэвтрүүлж хэрэгжүүлэх</li> <li>ТЗЭ-ийн мэдээллийн цахим санг хөгжүүлж, ашиглах</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Үйл ажиллагааны ил тод байдал хангагдаж нийлүүлэгч, хэрэглэгчдийн итгэл хүлээнэ.</li> </ul>
Санхүү	<ul style="list-style-type: none"> <li>ТЗЭ-дийн санхүүгийн үйл ажиллагааг шинэчлэгдсэн шаардлагын дагуу зохион байгуулж, хэрэгжүүлэх.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>ТЗЭ-дийн үйл ажиллагааны үр дүн, ашигт ажиллагааг уялдуулан тооцдог аргачлал боловсруулж, хэрэгжүүлэх</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Эрчим хүчний салбарын санхүүгийн үр ашиг сайжирна.</li> </ul>
Сургалт, хөгжил	<ul style="list-style-type: none"> <li>Ажилтнуудад үр дүнд суурилсан зохицуулалт хийх мэдлэг чадвар эзэмшүүлэх.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Дэлхий нийтэд хэрэглэгддэг зохицуулалтын арга хэрэгслүүдийг судалж өөрийн орны нөхцөлд хэрэгжүүлэх боломжийг тодорхойлж нэвтрүүлэх</li> <li>Үр дүнд суурилсан зохицуулалт хийх менежментийн арга барилыг хөгжүүлэх сургалтын хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Зохицуулалт хийх арга барил шинэчлэгдэнэ.</li> </ul>

**Стратегийн 3 дугаар зорилго: Инноваци, дэвшилтэт техник, технологид суурилсан эрчим хүчний хангамж, хэрэглээний хэмнэлт, үр ашгийг нэмэгдүүлэх**

Ерөнхий чиглэл	Зорилт	Үйл ажиллагаа	Дунд хугацааны хүрэх үр дүн
Тусгай зөвшөөрөл эзэмшигч, хэрэглэгч	<ul style="list-style-type: none"> <li>• Эрчим хүчний хэмнэлттэй техник, технологийг нэвтрүүлэх.</li> <li>• Эрчим хүчний хэрэглээний гол салбарууд болох барилга, аж үйлдвэрийн салбарт эрчим хүчний хэрэглээний үр ашгийг дээшлүүлэх.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Эрчим хүч хэмнэлтийн бодлогын хэрэгжилтийг хангаж, хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах</li> <li>• Эрчим хүч хэмнэлтийг дэмжсэн урамшууллын систем бий болгох, хэрэгжүүлэх</li> <li>• Эрчим хүч хэмнэх замаар салбарын алдагдлыг бууруулах ажлыг зохион байгуулах</li> <li>• Эрчим хүч хэмнэх, үр ашигтай зарцуулахад чиглэсэн нийтийн боловсрол олгох ажлыг зохион байгуулах, хэрэгжүүлэх</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Эрчим хүчний хэмнэлттэй дэвшилтэт техник, технологийн хэрэглээ нэмэгдсэн байна.</li> <li>• Эрчим хүчний бодит хэмнэлт гарсан байна.</li> </ul>
Дотоод үйл ажиллагаа	<ul style="list-style-type: none"> <li>• Эрчим хүч хэмнэлтийн талаарх бодлого, хууль тогтоомжийн уялдаа, тэдгээрийн хэрэгжилтийг сайжруулах.</li> <li>• Эрчим хүч хэмнэх үйл ажиллагаанд салбар дундын бодлогын уялдааг хангаж, бүх талын хамтын ажиллагаа бэхжүүлэх.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Эрчим хүч хэмнэлтийн бодлого, хуулийг хэрэгжүүлэхэд шаардлагатай эрх зүйн орчинд шинжилгээ хийх, нарийвчилсан хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх</li> <li>• Эрчим хүчний хэмнэлтийг тооцох аргачлал, норм, стандарт, дүрэм, журмыг боловсруулах, түүний хэрэгжилтийг хангах</li> <li>• Хамгийн бага эрчим хүч хэрэглэдэг машин, тоног төхөөрөмж, цахилгаан барааг шошгожуулах эрх зүйн баримт бичиг боловсруулах, батлуулах</li> <li>• Эрчим хүч хэмнэлтийн чиглэлээр гадаад, дотоодын хамтын ажиллагааг өргөжүүлж, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Эрчим хүч үйлдвэрлэх, дамжуулах, түгээх, ашиглах бүх хүрээнд хэмнэлтийн бодлогыг уялдуулан хэрэгжүүлдэг болно.</li> </ul>
Санхүү	<ul style="list-style-type: none"> <li>• Эрчим хүч хэмнэлтийг урамшуулах төсөв, хөрөнгийн эх үүсвэрийг бий болгох.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Эрчим хүч хэмнэлтийг урамшуулах төсвийн төсөл боловсруулах, түүний хэрэгжилтийг хангах</li> <li>• Эрчим хүчний үр ашгийг дээшлүүлж хэмнэлт гаргасан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад дэмжлэг үзүүлэх тарифын бодлогыг боловсруулж, хэрэгжүүлэх.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Эрчим хүчний бодит хэмнэлт гаргасан хэрэглэгчийг урамшуулдаг тогтолцоо бүрдсэн байна.</li> </ul>
Сургалт, хөгжил	<ul style="list-style-type: none"> <li>• Эрчим хүч хэмнэлтийн менежер, аудиторудыг тасралтгүй бэлтгэдэг систем бий болгох.</li> <li>• ЭХ-ний салбарын ажилтнуудад хэмнэлтийн талаар мэдлэг олгох.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Эрчим хүчний хэмнэлтийн чиглэлээр ажиллах хүний нөөцийн тогтвортой хөгжлийн бодлогыг боловсруулж, хэрэгжүүлэх</li> <li>• Хүний нөөцийг бэлтгэх, чадавхижуулах ажлыг зохион байгуулах</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Эрчим хүчний бодит хэмнэлт бий болох, түүнд тавих хяналт сайжирна.</li> </ul>



**Стратегийн 4 дүгээр зорилго: Эрсдэлд суурилсан хяналт шалгалтын тогтолцоог нэвтрүүлэх**

Ерөнхий чиглэл	Зорилт	Үйл ажиллагаа	Дунд хугацааны хүрэх үр дүн
Тусгай зөвшөөрөл эзэмшигч, хэрэглэгч	<ul style="list-style-type: none"> <li>Хяналт шалгалтыг стандартын дагуу бодит нөхцөл байдалд тулгуурлан хийдэг болох.</li> <li>ТЗЭ-ийн үйл ажиллагаанд гардаг зөрчил буурч, эрсдлээс урьдчилан сэргийлж, үр ашгийг нэмэгдүүлэх.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Эрсдлийн үнэлгээнд тулгуурлан тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагын биелэлтэнд хяналт шалгалт хийх</li> <li>Эрсдлээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах, арга зүйн зөвлөгөө өгөх, удирдамжаар хангах</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Хяналт шалгалтын үйл явц ил тод, шударга хийгддэг болно.</li> <li>ТЗЭ-ийн санхүү, техник, технологи, эдийн засгийн үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэл буурсан байна.</li> </ul>
Дотоод үйл ажиллагаа	<ul style="list-style-type: none"> <li>Эрсдэлд суурилсан хяналт шалгалт хийх эрх зүйн орчинг бүрдүүлэх.</li> <li>Эрсдлийг тооцох аргачлал боловсруулж хэрэгжүүлэх.</li> <li>Эрсдлийн үнэлгээнд суурилсан ангилал, мэдээллийн сан бий болгох.</li> <li>Хяналт шалгалтын төлөвлөгөөг эрсдлийн ангиллаас хамааруулан хийдэг тогтолцоог бий болгох.</li> <li>Хяналт шалгалт хийх, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх, сургалт зохион байгуулах ажлыг эрсдлийн ангиллаас хамааруулан зорилтот бүлгүүдэд ялгаатай хийдэг болох.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Эрсдэлд суурилсан хяналт шалгалтын журам, аргачлал, стандарт боловсруулах ажлыг зохион байгуулах</li> <li>ТЗЭ-ийн үйл ажиллагаанд тодорхой хугацаанд тогтмол эрсдлийн үнэлгээ хийх, ангилах, ангиллыг шинэчлэн тогтоох, мэдээллийн санг бүрдүүлэх</li> <li>Хяналт шалгалтын төлөвлөгөөг эрсдлээс хамааруулан боловсруулж, хэрэгжүүлэх</li> <li>Эрсдлийн түвшингээс хамааруулан зорилтот бүлгүүдийг тодорхойлох, тэдгээрт тохирсон хяналт шалгалт хийх, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх, сургалт зохион байгуулах</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Эрчим хүчний зохицуулалтын үйл ажиллагаа нь ТЗЭ-ийн бодит мэдээлэлд тулгуурладаг болно.</li> <li>Зохицуулах хорооны хяналт шалгалттай холбоотой нөөц (цаг хугацаа, хүний нөөц, өртөг зардал)-ийн хуваарилалт, зарцуулалт оновчтой болсон байна.</li> </ul>
Санхүү	<ul style="list-style-type: none"> <li>Хяналт шалгалт хийх, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх, сургалт зохион байгуулах санхүүжилтийг төлөвлөж хэрэгжүүлэх.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Эрсдэлд суурилсан хяналт шалгалтын тогтолцоог нэвтрүүлэх бэлтгэл ажлыг хангахад зориулагдсан төсвийг боловсруулж, хэрэгжүүлэх</li> <li>Эрсдлийн түвшингээс хамааруулан хяналт шалгалт хийх, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх, сургалт зохион байгуулахад шаардлагатай зардлыг төсөвлөж, хэрэгжүүлэх</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Хяналт шалгалт төлөвлөсөн хугацаандаа саадгүй, үр дүнтэй хэрэгждэг болно.</li> </ul>
Сургалт, хөгжил	<ul style="list-style-type: none"> <li>Албан хаагчдын эрсдэлд суурилсан хяналт шалгалт хийх мэдлэг, ур чадвар, хандлага, ажлын гүйцэтгэлийг сайжруулах.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Эрсдэлд суурилсан хяналт шалгалт хийх шаардлагатай мэдлэг чадварыг албан хаагчдад эзэмшүүлэх ажлыг зохион байгуулах</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Хорооны хяналт шалгалтын ажлын үр дүн сайжирсан байна.</li> </ul>

**Стратегийн 5 дугаар зорилго: Мэдлэг чадварт суурилсан мэргэшсэн манлайлагч байгууллага болох.**

Ерөнхий чиглэл	Зорилт	Үйл ажиллагаа	Дунд хугацааны хүрэх үр дүн
Тусгай зөвшөөрөл эзэмшигч, хэрэглэгч	<ul style="list-style-type: none"> <li>Хэрэглэгчдэд зориулан эрчим хүчний зохицуулалт, үнэ тариф, эрчим хүч хэмнэлтийн талаар ухуулга сурталчилгааны ажлыг зохион байгуулж хэрэгжүүлэх.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Хорооны үйл ажиллагааг олон нийтэд сурталчилах ажлыг тогтмолжуулж хэрэгжүүлэх</li> <li>Иргэд, байгууллагыг цаг үеэ олсон, хүртээмжтэй мэдээ, мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах</li> <li>Хэрэглэгч, нийлүүлэгчийн эрх ашгийг тэнцвэртэй хангасан бодлого, зохицуулалтыг боловсруулж хэрэгжүүлэх, түүнд хяналт тавих</li> <li>Хэрэглэгчийн эргэх холбоог эрчим хүчний үйл ажиллагааг сайжруулах арга, механизм болгож хэрэгжүүлэх</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>ЭХЗХ-ны үйл ажиллагаа нь иргэд, байгууллагын итгэлийг хүлээнэ</li> </ul>
Дотоод үйл ажиллагаа	<ul style="list-style-type: none"> <li>ЭХЗХ-ны үйл ажиллагааны дүрэм журмын хэрэгжилтэд хяналт тавьж хэрэгжилтийг сайжруулах .</li> <li>Эрчим хүчний салбарт инновацийг манлайлан хэрэгжүүлэх.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Эрчим хүчний салбарын хөгжлийн чиг хандлага, шинэлэг зүйлсийн талаар судалгаа, шинжилгээг тогтмол хийх</li> <li>Эрчим хүчний салбарын хөгжлийг дэмжсэн гадаад харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх</li> <li>Олон улсын туршлагаас суралцаж, түүнийг өөрийн орны онцлогт тохируулан хэрэгжүүлэх</li> <li>Эрчим хүчний чиглэлийн сургалт, эрдэм шинжилгээ, судалгааны байгууллага болон үйлдвэрлэлийн хамтын ажиллагааг санаачлан хэрэгжүүлэх</li> <li>Гадаад орнуудын болон олон улсын эрчим хүчний зохицуулалтын байгууллагууд, мэргэжлийн холбоодтой хамтарсан идэвхтэй үйл ажиллагаа, ажил хэргийн түншлэл бий болгох</li> <li>Аймаг, нийслэлийн эрчим хүчний зохицуулах зөвлөлийг мэргэжил, арга зүйн удирдлагаар тогтмол хангаж ажиллах</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Эрхэм зорилгоо хэрэгжүүлэхэд чиглэсэн хамтын үнэт зүйл бүхий соёл төлөвшинө.</li> <li>Үндэсний хэмжээнд эрчим хүчний салбарын хөгжлийг манлайлагч байгууллага болно</li> </ul>
Санхүү	<ul style="list-style-type: none"> <li>Санхүүгийн сахилга бат, ил тод байдлыг сайжруулах.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Санхүүгийн үйл ажиллагааны үр дүнг холбогдогч талуудад ойлгомжтой хэлбэрээр тогтмол мэдээлдэг болох</li> <li>Санхүүгийн бүртгэл, тооцооны үйл ажиллагааг стандартын дагуу хэрэгжүүлэх, түүнийг хэвшүүлэх</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Хорооны санхүүгийн чадавхи бэхжиж, санхүүгийн тогтвортой байдал хангагдана.</li> </ul>

<p>Сургалт, хөгжил</p>	<ul style="list-style-type: none"> <li>• Хорооны хүний нөөцийн чадавхийг сайжруулж, тогтвортой ажиллах нөхцлийг хангах.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Хорооны хүний нөөцийн бодлогын баримт бичиг боловсруулж хэрэгжүүлэх</li> <li>• Мэдлэг чадварт суурилсан хүний нөөцийн сонгон шалгаруулалт, албан тушаалд дэвшүүлэх тогтолцоог бүрдүүлж хэрэгжүүлэх</li> <li>• Ажлын гүйцэтгэл, мэдлэг чадварт суурилсан цалин урамшууллын тогтолцоог боловсруулж нэвтрүүлэх</li> <li>• Хүний нөөцийн сургалт, хөгжлийн хэрэгцээнд суурилсан хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлэх</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Хорооны үйл ажиллагааны үр дүн, албан хаагчдын ажлын гүйцэтгэл сайжирна</li> </ul>
------------------------	--	---	---



## **НАЙМ. ЭХЗХ-НЫ БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ**

Эрчим хүчний зохицуулах хорооны стратегийн зорилгыг хэрэгжүүлэхэд 2016 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн Эрчим хүчний зохицуулах хорооны 229-р тогтоолоор батлагдсан бүтэц, зохион байгуулалтыг өөрчлөх шаардлагатай байна. Хорооны бүтэц, зохион байгуулалтыг боловсруулахдаа дор дурдсан зарчмыг баримтлав. Үүнд:

- Стратегийн зорилгыг бүтцэд тусгасан байх зарчим (хорооны үйл ажиллагааны бүтцийн тогтолцоо, зохион байгуулалтын бүтэц нь түүний үйл ажиллагааны стратегийн зорилготой уялдсан байх);
- Эрх мэдлийн ялгаа зааг нь тодорхой, итгэл хүлээхүйц байх зарчим (бүтцийн нэгжүүд, тэдгээрийн удирдах албан тушаалын түвшин, нэр нь аль нэгж ямар асуудал эрхэлдэг, аль албан тушаал ямар эрх мэдэлтэй болохыг тодорхой мэдэж болохуйц байх, тэдгээрийн ажлын уялдаа, ажиллах чадвар нь итгэл хүлээхүйц байхын зэрэгцээ чиг үүргийн давхардалгүй байх);
- Үйл ажиллагааны үндсэн чиг үүргийг илэрхийлэх зарчим (байгууллагын нэр, бүтцээс тухайн байгууллагын үйл ажиллагааны дүр төрх харагдахуйц байх);
- Бүтцийн хувьд энгийн байх зарчим (Хорооны даргаас хамгийн доод нэгжээ хүртэл дөрвөөс илүүгүй шат дамжлагатай байх);
- Тэнцвэрийг хангах, хяналтын хүрээг тогтоох зарчим (аль болох хялбар удирдах, хянах боломжтой байх, удирдлагын чиг үүрэг, хүн хүчний болон бусад нөөцийг зөв хуваарилан хэрэглэгчийнхээ хэрэгцээнд нийцсэн үйлчилгээ үзүүлэх боломжийг бүрдүүлсэн байх);
- Мэргэшсэн үйл ажиллагааг дэмжсэн байх зарчим (ажилтнууд нь үйлчлүүлэгч буюу хэрэглэгчдэд дүрэм, журмыг чандлан баримталж өндөр мэргэшлийн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх);
- Хангалттай чадавхи, бодитой үйл ажиллагааны зарчим (чадавхиа бүрэн илрүүлэхэд чиглэсэн хэрэгжихүйц бөгөөд ажиллах чадвартай байх);

Дээрх зарчмыг баримтлан эрчим хүчний зохицуулах хороо нь Дотоод хяналт, аудитын нэгж; Тусгай зөвшөөрөл, хяналтын газар; Үнэ тариф, зах зээлийн газар; Эрчим хүч хэмнэлтийн газар; Захиргаа удирдлагын газар; Хэрэглэгч, орон нутгийн хэлтэс; Зах зээлийн судалгаа, хамтын ажиллагааны хэлтэс гэсэн бүтцийн нэгжүүдтэй ажиллахаар шинэчлэн зохион байгуулагдахаар байна (Зураг 2).

**Зураг2. Бүтэц, зохион байгуулалтын зураглал**



Эрчим хүчний зохицуулах хорооны дээрх бүтэц, зохион байгуулалтын хүрээнд Ажлын албаны харъяа нэгжүүдийн гүйцэтгэх үндсэн үүргийг дараах байдлаар тодорхойлов.

### **Ажлын албаны даргын эрх, үүрэг**

Ажлын албаны дарга нь Хорооны зохицуулалтын болон эрчим хүч хэмнэлтийн бодлого, төлөвлөлт, хэрэгжилтийн уялдааг хангах, зохицуулалтын үйл ажиллагааны үр нөлөө, чанарыг сайжруулах чиглэлд харьяа нэгжүүдийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, мэргэжлийн удирдлагаар хангах, ажлын албаны өдөр тутмын үйл ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах, хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлнэ.

### **Тусгай зөвшөөрөл, хяналтын газар, түүний чиг үүрэг**

Энэ нэгж нь эрчим хүч үйлдвэрлэх, дамжуулах, түгээх, диспетчерийн зохицуулалт хийх, хангах үйл ажиллагааг зохицуулах; эрчим хүчний үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, сунгах, өөрчлөх, түдгэлзүүлэх, хүчингүй болгох; тусгай зөвшөөрөл эзэмшигчийн тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг тогтоох, хэрэгжилтийг хянах; тусгай зөвшөөрөл эзэмшигч,

хэрэглэгчийн эрх ашгийг тэнцвэртэй хамгаалах үндсэн чиг үүргийн хүрээнд стратеги төлөвлөгөөний “Эрчим хүчний тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн үйл ажиллагааг зах зээлийн зарчимд нийцүүлэн үр дүнг чухалчилсан зохицуулалтаар хангах” гэсэн стратегийн зорилго 2, “Эрсдэлд суурилсан хяналт шалгалтын тогтолцоог нэвтрүүлэх” гэсэн стратегийн зорилго 4-т тодорхойлогдсон үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд голлох үүрэг, хариуцлагыг хүлээн ажиллана.

Тус газрын харъяанд Хэрэглэгч, орон нутгийн хэлтэс байх бөгөөд тус хэлтэс нь хэрэглэгчийн эрх ашгийг тэнцвэртэй хамгаалах, аймаг, нийслэлийн зохицуулах зөвлөлийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлж ажиллана.

#### ***Үнэ тариф, зах зээлийн газар, түүний чиг үүрэг***

Тус газар нь эрчим хүч үйлдвэрлэх, дамжуулах, түгээх, диспетчерийн зохицуулалт хийх, хангах үйл ажиллагааг зохицуулах; тариф тогтоох аргачлал боловсруулах, индексжүүлэх; тусгай зөвшөөрөл эзэмшигч болон хэрэглэгчийн тарифыг хянаж батлах; тусгай зөвшөөрөл эзэмшигч, хэрэглэгчийн эрх ашгийг тэнцвэртэй хамгаалах; тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн хүрээнд шударга өрсөлдөөнийг бий болгох нөхцлийг бүрдүүлэх үндсэн чиг үүргийн хүрээнд “Эрчим хүчний салбарыг зохицуулалттай, өрсөлдөөнт зах зээлийн зарчмаар ажиллах нөхцлийг бүрдүүлэх” гэсэн стратегийн зорилго 1, “Эрчим хүчний тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн үйл ажиллагааг зах зээлийн зарчимд нийцүүлэн үр дүнг чухалчилсан зохицуулалтаар хангах” гэсэн стратегийн зорилго 2-т тодорхойлсон үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг голлон хариуцаж ажиллана.

Энэ газрын харъяанд Зах зээлийн судалгаа, хамтын ажиллагааны хэлтэс ажиллана.

#### ***Эрчим хүч хэмнэлтийн газар, түүний чиг үүрэг***

Эрчим хүч хэмнэлтийн бодлогыг хэрэгжүүлэх, зохицуулах үндсэн чиг үүргийн хүрээнд энэхүү стратеги төлөвлөгөөнд тусгагдсан “Инноваци, дэвшилтэт техник, технологид суурилсан эрчим хүчний хангамж, хэрэглээний хэмнэлт, үр ашгийг нэмэгдүүлэх” 3 дугаар стратегийн зорилгыг хэрэгжүүлэхэд голлох үүрэг, хариуцлагыг хүлээн ажиллана.

***Захиргаа, удирдлагын газар, түүний чиг үүрэг***

Энэ нэгж нь стратегийн таван зорилгын хэрэгжилтийн уялдаа холбоог хангаж “Мэдлэг чадварт суурилсан мэргэшсэн манлайлагч байгууллага болох” гэсэн стратегийн 5 дугаар зорилгод чиглүүлэн ЭХЗХ-ны захиргааны болон хүний нөөцийн удирдлагын манлайллыг хангахад голлох үүрэгтэй ажиллана.

Энэ нэгжийн үйл ажиллагаа нь Хорооны дарга, зохицуулагчид, ажлын албаны дарга, зохион байгуулалтын бүтцийн нэгжүүд шийдвэр боловсруулан гаргах, хэрэгжүүлэхэд дотоод үйлчилгээ үзүүлэх, шаардлагатай зөвлөгөө, мэдээлэл, дэмжлэг үзүүлэх, үйл ажиллагааны уялдаа холбоог хангах, удирдлагын соёл, чадавхийг дээшлүүлэх, ажилтны ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг бүрдүүлэх замаар тасралтгүй, хэвийн жигд ажиллагааг хангахад чиглэнэ.


***Дотоод хяналт, аудитын нэгж, түүний үндсэн чиг үүрэг***

Энэ нэгж нь холбогдох хууль тогтоомжийн дагуу ЭХЗХ-ны зохион байгуулалтын бүтцийн нэгжүүдийн үйл ажиллагаанд дотоод хяналт болон дотоод аудитыг хийж, үйл ажиллагааны гүйцэтгэлийг сайжруулахад чиглэсэн дүгнэлт, зөвлөмж өгөх, удирдлагыг шийдвэр гаргахад дэмжлэг үзүүлэх чиг үүрэгтэй ажиллана. Дотоод хяналт, аудитын нэгж нь ажлаа Эрчим хүчний зохицуулах хорооны даргад ажлаа хариуцан тайлагнана.

## ЕС. ЭХЗХ-НЫ БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ БА СТРАТЕГИЙН ЗОРИЛГЫН УЯЛДАА

Эрчим хүчний зохицуулах хороо нь 2018-2021 онд хэрэгжүүлэх стратегийн зорилгуудыг хэрэгжүүлэхдээ тус хорооны нэгжүүдийн үйл ажиллагааны уялдаа холбоог дараах байдлаар хангаж ажиллана (Зураг 3).

**Зураг 3. Бүтэц, зохион байгуулалт ба Стратегийн зорилгуудын харилцан уялдаа**



Эрчим хүчний зохицуулах хороо нь бүтэц, зохион байгуулалтын хувьд нэгж тус бүр өөрсдийн үндсэн үүргээс гадна хорооны үндсэн зорилго, нэгж хоорондын уялдаа холбоо, нэгдмэл байдлыг хангах туслах үүргийг мөн гүйцэтгэнэ. Тухайлбал, эрчим хүчний зохицуулах хорооны стратегийн зорилгын биелэлтийг хангахын тулд тус хорооны нэгж тус бүр өөрсдийн үндсэн үүргийн хүрээнд дараах байдлаар **зорилгын манлайлагч буюу лидер**<sup>1</sup> болж ажиллана.


<sup>1</sup> **Зорилгын лидер** нь стратегийн тодорхой зорилгыг хэрэгжүүлэхэд манлайлах үүрэгтэй оролцоно. Хорооны зохион байгуулалтын нэгж бүр тодорхой нэг стратегийн зорилгыг өөрийн чиг үүргийн дагуу хариуцан ажиллахын зэрэгцээ, тухайн зорилгыг хэрэгжүүлэхэд бусад нэгж, ажилтнуудыг татан оролцуулах, хамтын шийдэл гаргах, үйл ажиллагааны уялдаа холбоог хангахад манлайлан ажиллана.

1. Тусгай зөвшөөрөл, хяналтын газар нь “Эрчим хүчний салбарыг зохицуулалттай, өрсөлдөөнт зах зээлийн зарчмаар ажиллах нөхцлийг бүрдүүлэх”, “Эрсдэлд суурилсан хяналт шалгалтын тогтолцоог нэвтрүүлэх” гэсэн хоёр ба дөрөвдүгээр стратегийн зорилгыг удирдан манлайлж ажиллана.
2. Үнэ тариф, зах зээлийн газар нь “Эрчим хүчний салбарыг зохицуулалттай, өрсөлдөөнт зах зээлийн зарчмаар ажиллах нөхцлийг бүрдүүлэх” гэсэн нэгдүгээр стратегийн зорилгыг удирдан манлайлж ажиллана.
3. Эрчим хүч хэмнэлтийн газар нь “Инноваци, дэвшилтэт техник, технологид суурилсан эрчим хүчний хангамж, хэрэглээний хэмнэлт, үр ашгийг нэмэгдүүлэх” гэсэн гуравдугаар стратегийн зорилгыг удирдан манлайлж ажиллана.
4. Захиргаа, удирдлагын газар нь “Мэдлэг чадварт суурилсан мэргэшсэн манлайлагч байгууллага болох” гэсэн тавдугаар стратегийн зорилгыг удирдан манлайлж ажиллана.

Гэхдээ стратегийн зорилгыг манлайлагч нэгжүүд нь үйл ажиллагааны хувьд харилцан уялдаатай ажиллах нь дээрх таван стратегийн зорилгын биелэлтийг хангах гол үндэс болно. Мөн Эрчим хүчний зохицуулах хорооны стратегийн зорилгын хүрээнд тус хорооны нэгжүүд нь өөрсдийн үйл ажиллагааны үндсэн чиглэл, стратегийн зорилготойгоо уялдуулан ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн боловсруулсан байна.

Стратегийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд дор дурдсан хамтын ажиллагааны хэлбэрийг ашиглах нь зүйтэй юм. Үүнд:

- 1. Төслийн ажил:** Тогтоосон хугацаанд, төлөвлөсөн нөөцийг ашиглан, тодорхой үр дүнд хүрэхэд чиглэгдсэн дэд төслүүдийг боловсруулж стратегийн төлөвлөгөөний зарим үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. Төслийн баг нь хорооны ажилтнууд болон мэргэшсэн зөвлөхүүдээс бүрдэж болно. Стратегийн төлөвлөгөөнд тусгагдсан зарим үйл ажиллагаанууд нь тодорхой нэг төслийн хүрээнд багц ажил болон хэрэгжих боломжтой.
- 2. Багаар ажиллах:** Стратегийн зорилтыг хангах үйл ажиллагаа бүтцийн нэгж дангаараа хариуцан хэрэгжүүлэхээс илүүтэйгээр мэргэшсэн, мэдлэг чадвартай ажилтнуудын оролцоог хангасан багийн зохион байгуулалтад тулгуурлах нь оновчтой юм.
- 3. Өдөр тутмын ажил:** Бүтцийн нэгжүүд нь чиг үүргийнхээ дагуу стратегийн төлөвлөгөөнд тусгагдсан үйл ажиллагааг шууд хариуцан хэрэгжүүлнэ.



## АРАВ. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

**Стратегийн 1 дүгээр зорилго:** Эрчим хүчний салбарыг зохицуулалттай, өрсөлдөөнт зах зээлийн зарчмаар ажиллах нөхцлийг бүрдүүлэх

№	Үйл ажиллагаа	Хариуцах нэгж (Зорилгын лидер)	Хугацаа	Ажиллах хэлбэр
1.1	Эрчим хүчний үнэ тарифын өнөөгийн нөхцөл байдлыг судалж, тарифын бодлогыг оновчлох	Үнэ тариф, зах зээлийн газар	2018	Төслийн ажил
1.2	ТЗЭ-ийн өртөг, зардалд дүн шинжилгээ хийж, тэдгээрийн зардлыг бууруулах урамшуулалт зохицуулалтын арга хэлбэрийг нэвтрүүлэх	Үнэ тариф, зах зээлийн газар	2018-2020	Төслийн ажил
1.3	Эрчим хүчний үнэ тарифыг индексжүүлэх ажлыг зохион байгуулж, хэрэгжүүлэх	Үнэ тариф, зах зээлийн газар	2018-2020	Төслийн ажил
1.4	Хэрэглэгчийн өргөдөл, гомдол, хүсэлтэд тулгуурласан эргэх холбоо бүхий үйл ажиллагааны нэгдсэн системийг нэвтрүүлж хэрэгжүүлэх	Хэрэглэгч, орон нутгийн хэлтэс	2018-2019	Багаар ажиллах
1.5	Зохицуулалттай, өрсөлдөөнт зах зээлийн зарчмаар ажиллах эрчим хүчний салбарын нөхцөл, боломжийг судлах	Үнэ тариф, зах зээлийн газар	2018-2019	Төслийн ажил/багаар ажиллах
1.6	Эрчим хүчний зах зээлийн загварууд, тэдгээрийн хөгжлийн чиг хандлагыг олон улсын түвшинд судлах	Зах зээлийн судалгаа, хамтын ажиллагааны хэлтэс	2018-2019	Багаар ажиллах
1.7	Эрчим хүчний салбарын нөхцөл байдалд тохирсон өрсөлдөөнийг дэмжсэн зах зээлийн загварыг судалж, боловсруулж гаргах	Үнэ тариф, зах зээлийн газар	2019-2020	Төслийн ажил/багаар ажиллах
1.8	Эрчим хүчний зах зээлд оролцогч талуудын үйл ажиллагааны зарчим, дүрэм, журмыг боловсруулж хэрэгжүүлэх	Тусгай зөвшөөрөл, хяналтын газар Захиргаа, удирдлагын газар	2018-2021	Багаар ажиллах
1.9	Нөөц (санхүү, хүн, материаллаг)-ийг үр ашигтай хуваарилж, зарцуулах төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх	Захиргаа, удирдлагын газар	2018-2019	Багаар ажиллах
1.10	Хөрөнгө оруулалтыг татах эрчим хүчний бодит өртгийг тодорхойлж, тарифын шинэтгэлийг үе шаттайгаар хэрэгжүүлэх	Үнэ тариф, зах зээлийн газар	2019-2021	Багаар ажиллах
1.11	Салбарын санхүү бүртгэлийн нэгдсэн бодлогын баримт бичгийг боловсруулж, хэрэгжүүлэх	Үнэ тариф, зах зээлийн газар Захиргаа, удирдлагын газар	2018-2019	Багаар ажиллах
1.12	Салбарын нягтлан бодох бүртгэлийн дансны нэгдсэн систем нэвтрүүлэх ажлыг зохион байгуулж, хэрэгжүүлэх.	Үнэ тариф, зах зээлийн газар Захиргаа, удирдлагын газар	2019-2020	Багаар ажиллах
1.13	Ажилтнуудын мэдлэг чадварын хэрэгцээг судалж, сургалтын хөтөлбөр төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх	Захиргаа, удирдлагын газар	2018-2021	Төслийн ажил



**Стратегийн 2 дугаар зорилго: Эрчим хүчний тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн үйл ажиллагааг зах зээлийн зарчимд нийцүүлэн үр дүнг чухалчилсан зохицуулалтаар хангах**

№	Үйл ажиллагаа	Хариуцах нэгж (Зорилгын лидер)	Хугацаа	Ажиллах хэлбэр
2.1	Эрчим хүчний зах зээлийн загварт нийцсэн тусгай зөвшөөрөл олгох, сунгах, цуцлах, өөрчлөх үйл ажиллагаанд тавигдах шаардлага, нөхцлийг боловсруулж, хэрэгжүүлэх	Тусгай зөвшөөрөл, хяналтын газар	2019-2021	Багаар ажиллах
2.2	ТЗЭ-ийн үйл ажиллагааны өнөөгийн нөхцөл байдалд судалгаа хийж, цаашид авах арга хэмжээг төлөвлөх	Тусгай зөвшөөрөл, хяналтын газар	2018	Багаар ажиллах
2.3	ТЗЭ-дийн үйл ажиллагааны үр дүнг хэмжих шалгуур үзүүлэлтийг тодорхойлох	Тусгай зөвшөөрөл, хяналтын газар	2018-2019	Багаар ажиллах
2.4	Орцод суурилсан механизмаас үр дүнд суурилсан зохицуулалтын механизмд шилжүүлэх ажлыг зохион байгуулж, хэрэгжүүлэх	Тусгай зөвшөөрөл, хяналтын газар	2019-2020	Төслийн ажил
2.5	ТЗЭ-дийн үйл ажиллагааны үр дүнг (хүний нөөцийн болон санхүүгийн менежментийн бодлого, техник, технологийн бодлого, эрчим хүч хэмнэлтийн бодлого, хөтөлбөр) чухалчилсан зохицуулалтын механизмыг нэвтрүүлж хэрэгжүүлэх	Тусгай зөвшөөрөл, хяналтын газар	2019-2021	Төслийн ажил
2.6	ТЗЭ-ийн мэдээллийн цахим санг хөгжүүлж, ашиглах	Тусгай зөвшөөрөл, хяналтын газар	2018	Төслийн ажил/багаар ажиллах
2.7	ТЗЭ-дийн үйл ажиллагааны үр дүн, ашигт ажиллагааг уялдуулан тооцдог аргачлал боловсруулж, хэрэгжүүлэх	Тусгай зөвшөөрөл, хяналтын газар Үнэ тариф, зах зээлийн газар	2018-2020	Багаар ажиллах
2.8	Дэлхий нийтэд хэрэглэгддэг зохицуулалтын арга хэрэгслүүдийг судалж өөрийн орны нөхцөлд хэрэгжүүлэх боломжийг тодорхойлж нэвтрүүлэх	Зах зээлийн судалгаа, хамтын ажиллагааны хэлтэс	2018-2019	Төслийн ажил
2.9	Үр дүнд суурилсан зохицуулалт хийх менежментийн арга барилыг хөгжүүлэх сургалтын хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх	Захиргаа, удирдлагын газар	2018-2019	Төслийн ажил

**Стратегийн 3 дугаар зорилго: Инноваци, дэвшилтэт техник, технологид суурилсан эрчим хүчний хангамж, хэрэглээний хэмнэлт, үр ашгийг нэмэгдүүлэх**

№	Үйл ажиллагаа	Хариуцах нэгж (Зорилгын лидер)	Хугацаа	Ажиллах хэлбэр
3.1	Эрчим хүч хэмнэлтийн бодлогын хэрэгжилтийг хангаж, хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах	Эрчим хүч хэмнэлтийн газар	2018	Өдөр тутмын ажил
3.2	Эрчим хүч хэмнэлтийг дэмжсэн урамшууллын систем бий болгох, хэрэгжүүлэх	Эрчим хүч хэмнэлтийн газар	2018-2019	Багаар ажиллах
3.3	Эрчим хүч хэмнэх замаар салбарын алдагдлыг бууруулах ажлыг зохион байгуулах	Эрчим хүч хэмнэлтийн газар Үнэ тариф, зах зээлийн газар	2019	Багаар ажиллах
3.4	Эрчим хүч хэмнэх, үр ашигтай зарцуулахад чиглэсэн нийтийн боловсрол олгох ажлыг зохион байгуулах, хэрэгжүүлэх	Эрчим хүч хэмнэлтийн газар Захиргаа, удирдлагын газар	2018-2021	Өдөр тутмын ажил
3.5	Эрчим хүч хэмнэлтийн бодлого, хуулийг хэрэгжүүлэхэд шаардлагатай эрх зүйн орчинд шинжилгээ хийх, нарийвчилсан хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх	Эрчим хүч хэмнэлтийн газар	2018-2019	Багаар ажиллах
3.6	Эрчим хүчний хэмнэлтийг тооцох аргачлал, норм, стандарт, дүрэм, журмыг боловсруулах, түүний хэрэгжилтийг хангах	Эрчим хүч хэмнэлтийн газар	2018-2019	Багаар ажиллах
3.7	Хамгийн бага эрчим хүч хэрэглэдэг машин, тоног төхөөрөмж, цахилгаан барааг шошгожуулах эрх зүйн баримт бичиг боловсруулах, батлуулах	Эрчим хүч хэмнэлтийн газар	2019-2020	Багаар ажиллах
3.8	Эрчим хүч хэмнэлтийн чиглэлээр гадаад, дотоодын хамтын ажиллагааг өргөжүүлж, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх	Эрчим хүч хэмнэлтийн газар Үнэ тариф, зах зээлийн газар	2018-2021	Төслийн ажил/багаар ажиллах
3.9	Эрчим хүч хэмнэлтийг урамшуулах төсвийн төсөл боловсруулах, түүний хэрэгжилтийг хангах	Эрчим хүч хэмнэлтийн газар Захиргаа, удирдлагын газар	2018-2019	Багаар ажиллах
3.10	Эрчим хүчний үр ашгийг дээшлүүлж хэмнэлт гаргасан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад дэмжлэг үзүүлэх тарифын бодлогыг боловсруулж, хэрэгжүүлэх	Эрчим хүч хэмнэлтийн газар Үнэ тариф, зах зээлийн газар	2019-2020	Багаар ажиллах
3.11	Эрчим хүчний хэмнэлтийн чиглэлээр ажиллах хүний нөөцийн тогтвортой хөгжлийн бодлогыг боловсруулж, хэрэгжүүлэх	Эрчим хүч хэмнэлтийн газар Захиргаа, удирдлагын газар	2018-2019	Багаар ажиллах
3.12	Хүний нөөцийг бэлтгэх, чадавхижуулах ажлыг зохион байгуулах	Захиргаа, удирдлагын газар	2018-2021	Өдөр тутмын ажил

**Стратегийн 4 дүгээр зорилго: Эрсдэлд суурилсан хяналт шалгалтын тогтолцоог нэвтрүүлэх**

№	Үйл ажиллагаа	Хариуцах нэгж (Зорилгын лидер)	Хугацаа	Ажиллах хэлбэр
4.1	Эрсдлийн үнэлгээнд тулгуурлан тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагын биелэлтэнд хяналт шалгалт хийх	Тусгай зөвшөөрөл, хяналтын газар	2018	Өдөр тутмын ажил
4.2	Эрсдлээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах, арга зүйн зөвлөгөө өгөх, удирдамжаар хангах	Тусгай зөвшөөрөл, хяналтын газар	2018	Өдөр тутмын ажил
4.3	Эрсдэлд суурилсан хяналт шалгалтын журам, аргачлал, стандарт боловсруулах ажлыг зохион байгуулах	Тусгай зөвшөөрөл, хяналтын газар	2018	Багаар ажиллах
4.4	ТЗЭ-ийн үйл ажиллагаанд тодорхой хугацаанд тогтмол эрсдлийн үнэлгээ хийх, ангилах, ангиллыг шинэчлэн тогтоох, мэдээллийн санг бүрдүүлэх	Тусгай зөвшөөрөл, хяналтын газар	2018-2021	Төслийн ажил/багаар ажиллах
4.5	Хяналт шалгалтын төлөвлөгөөг эрсдлээс хамааруулан боловсруулж, хэрэгжүүлэх	Тусгай зөвшөөрөл, хяналтын газар	2018-2021	Багаар ажиллах
4.6	Эрсдлийн түвшингээс хамааруулан зорилтот бүлгүүдийг тодорхойлох, тэдгээрт тохирсон хяналт шалгалт хийх, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх, сургалт зохион байгуулах	Тусгай зөвшөөрөл, хяналтын газар Захиргаа, удирдлагын газар	2018-2021	Багаар ажиллах
4.7	Эрсдэлд суурилсан хяналт шалгалтын тогтолцоог нэвтрүүлэх бэлтгэл ажлыг хангахад зориулагдсан төсвийг боловсруулж, хэрэгжүүлэх	Тусгай зөвшөөрөл, хяналтын газар Захиргаа, удирдлагын газар	2018	Багаар ажиллах
4.8	Эрсдлийн түвшингээс хамааруулан хяналт шалгалт хийх, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх, сургалт зохион байгуулахад шаардлагатай зардлыг төсөвлөж, хэрэгжүүлэх	Тусгай зөвшөөрөл, хяналтын газар Захиргаа, удирдлагын газар	2018-2021	Багаар ажиллах
4.9	Эрсдэлд суурилсан хяналт шалгалт хийх шаардлагатай мэдлэг чадварыг албан хаагчдад эзэмшүүлэх ажлыг зохион байгуулах	Захиргаа, удирдлагын газар	2018-2021	Өдөр тутмын ажил

**Стратегийн 5 дугаар зорилго: Мэдлэг чадварт суурилсан мэргэшсэн манлайлагч байгууллага болох**

№	Үйл ажиллагаа	Хариуцах нэгж (Зорилгын лидер)	Хугацаа	Ажиллах хэлбэр
5.1	Хорооны үйл ажиллагааг олон нийтэд сурталчилах ажлыг тогтмолжуулж хэрэгжүүлэх	Захиргаа, удирдлагын газар	2018	Өдөр тутмын ажил
5.2	Иргэд, байгууллагыг цаг үеэ олсон, хүртээмжтэй мэдээ, мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах	Захиргаа, удирдлагын газар	2018-2021	Өдөр тутмын ажил
5.3	Хэрэглэгч, нийлүүлэгчийн эрх ашгийг тэнцвэртэй хангасан бодлого, зохицуулалтыг боловсруулж хэрэгжүүлэх, түүнд хяналт тавих	Тусгай зөвшөөрөл, хяналтын газар	2018-2019	Багаар ажиллах

Эрчим хүчний зохицуулах хорооны Стратегийн баримт бичиг /2018-2021/

5.4	Хэрэглэгчийн эргэх холбоог эрчим хүчний үйл ажиллагааг сайжруулах арга, механизм болгож хэрэгжүүлэх	Хэрэглэгч, орон нутгийн хэлтэс	2019	Багаар ажиллах
5.5	Эрчим хүчний салбарын хөгжлийн чиг хандлага, шинэлэг зүйлсийн талаар судалгаа, шинжилгээг тогтмол хийх	Зах зээлийн судалгаа, хамтын ажиллагааны хэлтэс	2018-2021	Багаар ажиллах
5.6	Эрчим хүчний салбарын хөгжлийг дэмжсэн гадаад харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх	Зах зээлийн судалгаа, хамтын ажиллагааны хэлтэс	2018-2021	Өдөр тутмын ажил
5.7	Олон улсын туршлагаас суралцаж, түүнийг өөрийн орны онцлогт тохируулан хэрэгжүүлэх	Зах зээлийн судалгаа, хамтын ажиллагааны хэлтэс	2018-2021	Багаар ажиллах
5.8	Эрчим хүчний чиглэлийн сургалт, эрдэм шинжилгээ, судалгааны байгууллага болон үйлдвэрлэлийн хамтын ажиллагааг санаачлан хэрэгжүүлэх	Зах зээлийн судалгаа, хамтын ажиллагааны хэлтэс	2018-2021	Өдөр тутмын ажил
5.9	Гадаад орнуудын болон олон улсын эрчим хүчний зохицуулалтын байгууллагууд, мэргэжлийн холбоодтой хамтарсан идэвхтэй үйл ажиллагаа, ажил хэргийн түншлэл бий болгох	Зах зээлийн судалгаа, хамтын ажиллагааны хэлтэс	2018-2021	Өдөр тутмын ажил
5.10	Аймаг, нийслэлийн эрчим хүчний зохицуулах зөвлөлийг мэргэжил, арга зүйн удирдлагаар тогтмол хангаж ажиллах	Хэрэглэгч, орон нутгийн хэлтэс	2018-2021	Өдөр тутмын ажил
5.11	Санхүүгийн үйл ажиллагааны үр дүнг холбогдогч талуудад ойлгомжтой хэлбэрээр тогтмол мэдээлдэг болох	Захиргаа, удирдлагын газар	2018-2021	Өдөр тутмын ажил
5.12	Санхүүгийн бүртгэл, тооцооны үйл ажиллагааг стандартын дагуу хэрэгжүүлэх, түүнийг хэвшүүлэх	Захиргаа, удирдлагын газар	2018-2019	Өдөр тутмын ажил
5.13	Хорооны хүний нөөцийн бодлогын баримт бичиг боловсруулж хэрэгжүүлэх	Захиргаа, удирдлагын газар	2018-2019	Төслийн ажил
5.14	Мэдлэг чадварт суурилсан хүний нөөцийн сонгон шалгаруулалт, албан тушаалд дэвшүүлэх тогтолцоог бүрдүүлж хэрэгжүүлэх	Захиргаа, удирдлагын газар	2018-2019	Багаар ажиллах
5.15	Ажлын гүйцэтгэл, мэдлэг чадварт суурилсан цалин урамшууллын тогтолцоог боловсруулж нэвтрүүлэх	Захиргаа, удирдлагын газар	2018-2019	Багаар ажиллах
5.16	Хүний нөөцийн сургалт, хөгжлийн хэрэгцээнд суурилсан хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлэх	Захиргаа, удирдлагын газар	2018-2021	Багаар ажиллах